



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/19/НА-СТА-ОНТС

|                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Цахим хуудас:<br/><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Алтай хот<br/>2022 он</p> | <p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br/>Утас: 70483413      Цахим хаяг:<br/>tuvshinbayarkh@audit.gov.mn<br/>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br/>Утас: 70484055      Цахим хаяг:<br/>erdenechimegd@audit.gov.mn<br/>Аудитор                      Э.Сүнжидмаа<br/>Утас: 88048599      Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn</p> |
|---------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

|                                                                           |    |
|---------------------------------------------------------------------------|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                 | 3  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                          | 3  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                       | 4  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                        | 7  |
| 3.1 Ерөнхий зүйл.....                                                     | 8  |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                      | 8  |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                           | 8  |
| 3.4 Материаллаг байдал.....                                               | 9  |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                 | 9  |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                      | 9  |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....                  | 10 |
| 3.8 Аудитын гол асуудал.....                                              | 10 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 10 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....                           | 10 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                                     | 10 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                             | 10 |
| 4. Аудитын илрүүлэлт .....                                                | 10 |
| 4.1 Залруулсан алдаа .....                                                | 10 |
| 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                         | 11 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |
| АИТХ     | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал                        |
| БСУГ     | Боловсрол соёл урлагийн газар                               |



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 22 № 08

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Халамжийн сангийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020056

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                       | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---------------|------------------------------------------------|----------------|-----------------|
|               | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]      | 527,142.42     | 9,750.00        |
| 3101          | Кассанд байгаа бэлэн мөнгө                     | 0.00           | 0.00            |
| 3102          | Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөг/ [4]+[5]     | 527,142.42     | 9,750.00        |
| 310201        | Банкинд байгаа бэлэн мөнгө/Улсын төсөв/        | 504,136.02     | 9,750.00        |
| 3.1.4.1       | Банкинд байгаа бэлэн мөнгө/ОНТөсөв/            | 23006.4        |                 |
| 33            | Байгууллагаас авах авлага                      | 0.00           | 0.00            |
| 33            | Хувь хүнээс авах авлага                        | 0.00           | 0.00            |
| 33            | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]                | 527,142.42     | 9,750.00        |
|               | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                    | 0.00           | 0.00            |
|               | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]                   | 527,142.42     | 9,750.00        |
| 41            | Богино хугацаат өр төлбөр [18]+[21]+[22]+[23]  | -              | -               |
| 4.1           | Өглөг [18]+[21]+[22]+[23]                      |                |                 |
| 4101          | Хэлтэс хоорондын тооцоо [19]+[20]              | 0.00           | 0.00            |
| 410101        | Байгууллаг хоорондын тооцоо УТ                 | 0.00           | 0.00            |
| 410102        | Байгууллаг хоорондын тооцоо ОН                 | 0.00           | 0.00            |
| 410301        | Хувь хүнд өгөх улсын төсвийн өглөг             |                |                 |
| 410302        | Хувь хүнд өгөх ОНТөсвийн өглөг                 | 0.00           | 0.00            |
| 410302        | Байгууллагад өгөх ОНТөсвийн өглөг              | 0.00           | 0.00            |
| 4             | Урьдчилж орсон орлого                          | 0.00           | 0.00            |
| 41040101      | Урьдчилж орсон орлого Улсын төсөв              | 0.00           | 0.00            |
| 41040102      | Урьдчилж орсон орлого Орон нутаг               | 0.00           | 0.00            |
| 41            | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [16]+[24]     | -              | -               |
| 41            | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН                  | 0.00           | 0.00            |
| 41            | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [27]+[28]                | -              | -               |
| 510301        | Өмнөх үеийн үр дүн                             | 367,332.91     | 527,142.86      |
| 5103010002    | Өмнөх үеийн үр дүн орон нутаг                  |                |                 |
| 510302        | Тайлант үеийн үр дүн                           | 159,809.95     | (517,392.86)    |
| 5103020002    | Тайлант үеийн үр дүн орон нутаг                | 0.00           | 0.00            |
| 0             | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]   | 159,809.95     | (517,392.86)    |
| 0             | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34] | 527,142.86     | 9,750.00        |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Мөр         | Үзүүлэлт                                                             | ӨМНӨХ ОН         | ТАЙЛАНТ ОН      |
|-------------|----------------------------------------------------------------------|------------------|-----------------|
| 1303        | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]                                  | 8,819,599,330.00 | 3,605,653,000.0 |
| 130301      | Улсын төсвийн санхүүжилтын орлого                                    | 8,714,599,330.00 | 3,507,253,000.0 |
| 130302      | Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого                             | 105,000,000.00   | 98,400,000.0    |
| 14          | Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]                           | 3,469,798.74     | 206,284.1       |
| 1401011     | Улсын төсвийн хүүгийн орлого                                         | 3,444,651.19     | 46,220.6        |
| 1401012     | Улсын төсвийн бусад орлого                                           | 0                | 160,000.0       |
| 1401021     | Орон нутгийн төсвийн хүүгийн орлого                                  | 25,147.55        | 63.5            |
| 1401022     | Орон нутгийн төсвийн бусад орлого                                    | 0                | -               |
| 1           | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]                                  | 8,823,069,128.74 | 3,605,859,284.1 |
| 2603        | Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]                                         | 69,964,178.79    | 55,425,061.99   |
| 260301      | Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв                                       | 36,559,496.34    | 39,801,991.61   |
| 260302      | Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв                                | 33,404,682.45    | 15,623,070.38   |
| 2701+2702   | НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [38]-р мөр               | 8,726,376,590.00 | 3,524,877,665.0 |
| 2701021100  | Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт                             | 4,072,390,140.00 | 947,736,475.0   |
| 2701021200  | Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт                              | 1,080,503,170.00 | 932,862,000.0   |
| 2701021300  | Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт                         | 704,018,420.00   | 658,726,660.0   |
| 2701021500  | Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт | 21,600,000.00    | 46,800,000.0    |
| 2701010900  | ахмад настны үйлчилгээ                                               | 382,343,980.00   | 271,246,250.0   |
| 27010       | ихэр хүүхдийн тэтгэмж                                                | 18,000,000.00    |                 |
| 2701021604  | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт                      | 185,293,220.00   | 151,195,230.0   |
| 27010010700 | Цалинтай ээж хөтөлбөрийн зардал                                      | 131,805,080.00   |                 |
| 2701010800  | өрх толгойлсон эх эцэг хөтөлбөрийн зардал                            | 129,330,420.0    |                 |
| 2701022000  | Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн                    | 19,647,650.00    |                 |
| 2701023000  | ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт                       | 49,997,500.00    | 36,000,000.0    |
| 2701024000  | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний                          | 815,918,000.00   | 480,311,050.0   |
| 2701025     | Туршилтын үйлчилгээ                                                  | 0                | -               |
| 2702010101  | Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт                            | 649,000,000.00   |                 |
| 27020102    | Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж                | 66,969,010.00    |                 |
| 2701020400  | Насны хишгийн зардал                                                 | 399,560,000.00   |                 |
| 2702020308  | Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал                      | 24,148,000.00    | 24,852,300.0    |
| 2702026000  | Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж                                       | 0                | -               |
|             | Банкны шимтгэл [40]+[43]                                             | 2,826,000.00     |                 |
| 0           | Банкны шимтгэл ОНТөсөв [44]+[45]+[46]+[47]                           | 2,826,000.00     |                 |
| 2702020301  | Банкны шимтгэл Халамжийн сан                                         | 2,420,550.00     | 1,221,650.0     |
|             | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[39]                      | 8,822,909,318.79 | 3,606,376,677.0 |
|             | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[48]                                 | 159,809.95       | (517,392.86)    |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Д/д         | Үзүүлэлт                                                             | Өмнөх оны<br>гүйцэтгэл | Тайлант оны<br>гүйцэтгэл |
|-------------|----------------------------------------------------------------------|------------------------|--------------------------|
| 1303        | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО                                         | 8,819,599,330.00       | 3,605,653,000.00         |
| 130301      | Улсын төсвийн санхүүжилтын орлого                                    | 8,714,599,330.00       | 3,507,253,000.00         |
| 130302      | Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого                             | 105,000,000.00         | 98,400,000.00            |
| 1401        | Бараа, үйлчилгээний орлого                                           | 16,337,278.74          | 12,368,199.13            |
| 1401011     | Улсын төсвийн хүүгийн орлого                                         | 3,444,651.19           | 46220.59                 |
| 1401012     | Улсын төсвийн бусад орлого                                           | 0                      | 160,000.00               |
| 1401021     | Орон нутгийн төсвийн хүүгийн орлого                                  | 25,147.55              | 63.54                    |
| 1401022     | Орон нутгийн төсвийн бусад орлого                                    |                        |                          |
| 1401013     | Улсын төсвийн буцаасан орлого                                        | 12,867,480.00          | 12,161,915.00            |
| 1401023     | Орон нутгийн төсвийн буцаасан орлого                                 | 0.00                   | 0.00                     |
|             | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ                                   | 8,835,936,608.74       | 3,618,021,199.13         |
| 2701+2702   | НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ                                 | 8,739,244,070.00       | 3,537,039,580.00         |
| 2701021100  | Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт                             | 4,076,282,140.00       | 951,813,970.00           |
| 2701021200  | Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт                              | 1,082,255,780.00       | 935,949,670.00           |
| 2701021300  | Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт                         | 705,666,290.00         | 658,726,660.00           |
| 2701021300  | Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт | 21,600,000.00          | 46,800,000.00            |
| 27010010900 | Ахмад настны хөнгөлөлтийн үйлчилгээ                                  | 382,343,980.00         | 271,570,050.00           |
| 27010       | ихэр хүүхдийн тэтгэмж                                                | 18,000,000.00          |                          |
| 2701021604  | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт                      | 185,608,220.00         | 151,195,230.00           |
| 2701010700  | Цалинтай ээж хөтөлбөрийн зардал                                      | 132,255,080.00         |                          |
| 2701010800  | Өрх толгойлсон эх эцэг хөтөлбөрийн зардал                            | 129,330,420.00         |                          |
| 2701022000  | Жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн                    | 21,017,650.00          |                          |
| 2701023000  | ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт                       | 49,997,500.00          | 36,000,000.00            |
| 2701024000  | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний                          | 819,278,000.00         | 484,984,000.00           |
| 2702010101  | Алдарт эхийн одонгийн мөнгөний зарцуулалт                            | 649,000,000.00         |                          |
| 27020102    | Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт      | 66,969,010.00          |                          |
| 2702010400  | насны хишгийн зардал                                                 | 399,640,000.00         |                          |
| 2702020308  | Амжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал                      | 24,148,000.00          | 24,852,300.00            |
|             | Банкны шимтгэл [39]+[42]                                             | 2,420,550.00           | 1,221,650.00             |
|             | Банкны шимтгэл ОНТөсөв [43]+[44]+[45]+[46]                           | 2,420,550.00           | 1,221,650.00             |
| 2603        | Төсөвт төвлөрүүлэх [51]+[52]                                         | 69,964,178.79          | 55,425,061.99            |
| 260301      | Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв                                       | 36,559,496.34          | 39,801,991.61            |
| 260302      | Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв                                | 33,404,682.45          | 15,623,070.38            |
|             | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН                                   | 8,835,776,798.79       | 3,618,538,591.99         |
|             | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                                 | 159,809.95             | -517,392.86              |
|             | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                                            | 159,809.95             | -517,392.86              |
|             | Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл                      | 367,332.91             | 527,142.86               |
|             | Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                     | 527,142.86             | 9,750.00                 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Д/д | Үзүүлэлт                                     | Засгийн оруулсан капитал | Дахин үнэлгээний | Хуримтлагд үр дүн | Засгийн хувь нийт дүн |
|-----|----------------------------------------------|--------------------------|------------------|-------------------|-----------------------|
| 1   | 2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл           | 0                        | 0                | -                 | -                     |
| 2   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                   | 0                        | 0                | 0                 | -                     |
| 3   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт      | 0                        | 0                | 0                 | -                     |
| 4   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт    | 0                        | 0                | 0                 | -                     |
| 5   | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0                        | 0                | 0                 | -                     |
| 6   | Тайлант үеийн үр дүн                         | 0                        | 0                | 159,809.95        | 159,809.95            |
| 7   | 2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл           | 0                        | 0                | 527,142.86        | 527,142.86            |
| 8   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт   | 0                        | 0                | 0                 | -                     |
| 9   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                   | 0                        | 0                | 0                 | -                     |
| 10  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт      | 0                        | 0                | 0                 | -                     |
| 11  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт    | 0                        | 0                | 0                 | -                     |
| 12  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0                        | 0                | 0                 | -                     |
| 13  | Тайлант үеийн үр дүн                         | 0                        | 0                | (517,392.86)      | (517,392.86)          |
| 14  | 2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл           | 0                        | 0                | 9,750.00          | 9,750.00              |
| 15  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт   | 0                        | 0                | 0                 | 0                     |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

|    | Сангийн орлого                                             | Төлөвлөгөө       | цэвэр гүйцэтгэл  | Төсвийн хэтрэлт хэмнэлт |
|----|------------------------------------------------------------|------------------|------------------|-------------------------|
| 1  | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл                            | 0                |                  | 0                       |
| 2  | Сангийн үйл ажиллагааны зардал                             | 3,605,653,000.00 | 3,550,951,615.00 | 54,701,385.00           |
| 3  | Алдарт эхийн одонгийн мөнгө                                |                  |                  | 0.00                    |
| 4  | үзүүлсэн тэтгэмж тусламж, хөнгөлөлт                        |                  |                  | 0.00                    |
| 5  | Насны хишиг                                                |                  |                  | 0.00                    |
| 6  | АДЗөвлөлийн урамшуулал                                     | 26,065,000.00    | 24,852,300.00    | 1,212,700.00            |
| 7  | Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхэд олгосон тусламж |                  |                  | 0.00                    |
| 8  | Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ       | 43,400,000.00    | 36,000,000.00    | 7,400,000.00            |
| 10 | Банкны шимтгэл                                             | 1,400,000.00     | 1,221,650.00     | 178,350.00              |
| 11 | Цалинтай ээж хөтөлбөрийн зардал                            |                  |                  | 0.00                    |
| 12 | Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн зардал                 |                  |                  | 0.00                    |
| 13 | Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал                  | 271,256,000.00   | 271,246,250.00   | 9,750.00                |
| 14 | Халамжийн тэтгэвэрийн сангийн зарцуулалт                   | 965,000,000.00   | 947,736,475.00   | 17,263,525.00           |
| 15 | Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт                    | 933,000,000.00   | 932,862,000.00   | 138,000.00              |
| 16 | Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт               | 668,000,000.00   | 658,726,660.00   | 9,273,340.00            |
| 17 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт            | 159,996,000.00   | 151,195,230.00   | 8,800,770.00            |
| 18 | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт     | 482,536,000.00   | 480,311,050.00   | 2,224,950.00            |
| 19 | Ихэр хүүхдийн тэтгэмж                                      |                  |                  | 0.00                    |
| 20 | Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэж     | 55,000,000.00    | 46,800,000.00    | 8,200,000.00            |
| 21 | Сангийн үйл ажиллагааны зардалын дүн                       | 3,605,653,000.00 | 3,550,951,615.00 | 54,701,385.00           |
| 22 | УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ                                   | 3,605,653,000.00 | 3,560,224,955.00 |                         |
| 23 | Тохируулгын дүн                                            |                  | -                |                         |
| 24 | МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ                           |                  |                  |                         |

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 34 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Халамжийн сан нь Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохицуулах хуулиуд, нийгмийн халамжийн багц хуулиудын хүрээнд нийгмийн тогтвортой хөгжлийг ханахад чиглэгдсэн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлж буй төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 8,800.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 176.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 141.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 3,606.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 72.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 57.7 сая төгрөгөөр тооцсон. Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Говь-Алтай аймгийн Халамжийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 98.5 хувиар буюу 0.5 сая төгрөгөөр буурсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.09 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн цэвэр мөнгөн гүйлгээнээс шалтгаалж байна.

Халамжийн сангийн тухайд бараа материал, үндсэн хөрөнгө бүртгэлгүй байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант хугацааны 0.5 сая төгрөгийн үр дүнгээр буурч 5.1 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 10,770.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг төслөөс 7,164.7 сая төгрөг мянган төгрөгөөр бууруулж баталжээ. Энэ нь халамжийн үйлчилгээ цахим хэлбэрт шилсэнтэй холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвөөс санхүүжүүлэхээр 3,605.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 98.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тайлант оны эхэнд 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй, улсын төсвөөс 3,507.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 98.4 сая төгрөгийн санхүүжилт авч, арилжааны банкны хүүгийн орлого 0.05 сая төгрөг орж, 3,468.2 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, халамжийн хөнгөлөлт үйлчилгээнд, 82.8 сая төгрөгийг онцгой тохиолдлын амьжиргааг дэмжих, ОНО түшиглэсэн халамжийн үйлчилгээнд зарцуулж, улсын төсөвт 39.8 сая төгрөг, орон нутгийн төсөвт 15.6 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн тухайд нэмэлт санхүүжилтийн дансаар гарсан гүйлгээ байхгүй.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 127 мэдээллээс 20 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон бөгөөд 2.0 сая төгрөгийг барагдуулаагүй үлдэгдэлтэй бөгөөд хэрэгжүүлэхээр хуулийн байгууллагад хандсан байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

##### **Дараа жилийн аудитаар**

- Өмнөх аудитын шийдвэрийн үлдэгдлээс 2.0 сая төгрөгийг барагдуулж ажиллах.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 42.5 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын хувьд залруулга хийгдээгүй болно.

#### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### 4.3 Албан шаардлага

Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зардалд 42.5 сая төгрөг зарцуулсан боловч худалдан авах ажиллагаа зарлаагүй нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 тоот тогтоол "Босго үнэ шинэчлэн тогтоох тухай", гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |      | Үүнээс    |     |               |     |                 |      |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|------|---------|-----|
|     |                                     |                      |      | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |      | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн  | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн  | Тоо     | Дүн |
| 1   | Халамжийн сан                       | 1                    | 42.5 |           |     |               |     | 1               | 42.5 |         |     |
|     | Дүн                                 | 1                    | 42.5 |           |     |               |     | 1               | 42.5 |         |     |